

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Марсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 04/183
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РЕНЧИНЛХҮМБЭ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.НАНСАЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рэнчинлхүмбэ сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлж байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 172,973.6 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 25,717.7 мянган төгрөгийн эмийн шууд худалдан авсан, хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү худалдан авалт хийж нөөцөлсөн зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын

стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	198821351.07	318,014,651.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,189,097.33	172,973,648.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,189,097.33	172,973,648.24
3121	Төгрөг	14,189,097.33	172,973,648.24
31211	Төрийн сангийн харилцах	14,189,097.33	172,973,648.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
3121	Төгрөг	14,189,097.33	172,973,648.24
31211	Төрийн сангийн харилцах	14,189,097.33	172,973,648.24
33	АВЛАГА	61,805,200	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	155,029.30
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	61,805,200	00.00
335	Бусад авлага	00.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	122,827,053.73	144,885,973.91
351	Түүхий эд материал	55,590,557.67	45,074,643.72
35110	Тусгай зориулалттай материал	6,484,384.32	00.00
35130	Эм боох материал	49,106,173.35	45,074,643.72
354	Хангамжийн материал	67,236,496.07	99,811,330.19
35410	Бичиг хэргийн материал	2,695,570.00	3,240,810.00
35420	Аж ахуйн материал	50,310,060.22	65,556,309.52
35430	Сэлбэг хэрэгсэл	6,200,000	2,160,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,868,950.30	12,373,999.70
35450	Хүнсний материал	1,131,915.55	7,415,826.65
35460	Бусад хангамжийн материал	2,030,000	9,064,384.32
35470	Мал амьтад	00.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	421,546,622.77	323,119,856.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	421,546,622.77	323,119,856.26
392	Биет хөрөнгө	391,636,622.77	293,319,856.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	206,325,849.00	206,325,849.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-99,404,638.84	113,092,530.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	125,158,686.00	137,304,686.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-54,685,009.71	-81,731,240.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	297,206,508.56	342,137,415.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,843,896.05	221,403,534.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,714,079.00	40,436,800.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,888,144.19	-17,359,716.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,709,179.00	6,709,179.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,655,990.00	-6,007,053.00
393	Биет бус хөрөнгө	29,910,000	29,799,999.96
39301	Програм хангамж	825,000	825,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000	-385,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө	29,360,000	29,360,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	620,367,973.84	641,134,507.71
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,031,029.40	00.00

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,031,029.40	00.00
413	Өглөг	2,031,029.40	00.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	1,694,179.00	00.00
4132	Бараа үйлчилгээний зардлыг өглөг	336,850.40	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	618,336,944.44	641,134,507.71
51	Засгийн газрын хувь оролцоо	618,336,944.44	641,134,507.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	269,328,439.00	269,328,439.00
51101	Өмч: - төрийн	269,328,439.00	269,328,439.00
512	Хуримтлагдсан үр дүн	248,308,439.00	271,105,850.91
51210	Өмнөх үеийн үр дүн	248,308,439.00	248,308,287.64
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	22,797,563.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,700,217.80	100,700,217.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	620,367,973.84	641,134,507.71

2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А
/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,263,986,831.67	963,911,276.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	361,503,111.67	85,766,839.04
120	Нийтлэг татварын бус орлого	361,503,111.67	85,766,839.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	361,503,111.67	85,766,839.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	361,503,111.67	85,766,839.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	496,006,300.00	878,144,437.67
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	496,006,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	347,421,010.00	1,054,000
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,525,800.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,681,810.00	1,054,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,753,400.00	00.00
131107	ЭМДсангийн нэмэлт орлого	276,460,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,744,000.00	37,157,337.67
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,744,000.00	37,157,337.67
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	40,312,410.00	839,933,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	40,312,410.00	839,933,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,052,986,110.30	936,752,821.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,052,986,110.30	936,752,821.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,013,186,110.30	933,003,545.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	447,933,629.00	480,765,490.14
210101	Үндсэн цалин	447,933,629.00	333,132,334.24
210102	Нэмэгдэл	00.00	105,660,016.00

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,822,00.00
210104	Урамшуулал	00.00	31,774,934.10
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	6,376,205.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,384,511.00	51,081,185.99
210201	Тэтгэврийн даатгал	42,312,618.00	35,633,406.39
210202	Тэтгэмжийн даатгал	3,986,339.00	4,192,164.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,417,373.00	3,286,531.24
210204	Ажилгүйдлийн даатгал	770,165.00	639,797.39
210205	Эрүүл мэндийн даатгал	7,898,016.00	7,329,286.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,654,594.00	16,475,073.93
210301	Гэрэл, цахилгаан	2,529,594.00	3,616,123.63
210302	Түлш, халаалт	12,925,000.00	11,658,950.30
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,565,044.38	60,693,915.00
210401	Бичиг хэрэг	1,239,020.00	4,652,560.00
210402	Тээвэр, шатахуун	27,078,080.00	37,160,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,394,309.67	2,710,000.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,129,000.00	242,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,724,634.71	15,928,565.00
2105	Нормативт зардал	339,722,434.45	113,887,810.14
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	321,926,087.20	102,827,721.84
210502	Хоол, хүнс	15,802,347.25	11,060,088.90
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,994,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,669,800.00	14,633,200.00
210601	Багаж хэрэгсэл	170,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,499,800.00	14,633,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,474,000.00	1,932,000.00
210702	Дотоод албан томилолт	1,474,000.00	1,932,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	958,000.00	2,554,049.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,444,995.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.00	226,080.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,000.00	162,974.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	00.00
210806	Мэдээлэлийн технологийн үйлчилгээний хөлс	506,000.00	00.00
210806	Газрын төлбөр	65,000.00	.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,824,097.47	190,980,820.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,961,050.00	11,527,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,863,047.47	179,452,970.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,800,000.00	3,749,276.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,800,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	00.00
2610	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,749,276.37
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,749,276.37

Аудитын код: ХӨА-2023/92/НА-СТА-ТШЗ

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>211,000,721.37</u>	<u>27,158,455.11</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,260,120.44	<u>4,360,891.84</u>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,260,120.44	4,360,891.84
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-8,260,120.44	-4,360,891.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>202,740,600.93</u>	<u>22,797,563.27</u>

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>842,076,620.00</u>	<u>939,949,637.67</u>
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	87,914,297.33
	Нийтлэг татварын бус орлого	00.00	87,914,297.33
	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	87,914,297.33
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	87,914,297.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>842,076,620.00</u>	<u>878,144,437.67</u>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	496,006,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	<u>287,013,910.00</u>	<u>1,054,000.00</u>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,525,800.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,079,910.00	1,054,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,753,400.00	00.00
131107	ЭМДсангийн нэмэлт орлого	214,654,800.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	<u>18,744,000.00</u>	<u>37,157,337.67</u>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,744,000.00	37,157,337.67
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	<u>40,312,410.00</u>	<u>828,013,100.00</u>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	40,312,410.00	828,013,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>741,587,522.67</u>	<u>737,244,510.39</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>741,587,522.67</u>	<u>737,244,510.39</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>701,787,522.67</u>	<u>737,244,510.39</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<u>443,527,182.00</u>	<u>476,065,821.95</u>
210101	Үндсэн цалин	299,529,003.00	311,618,213.02
210102	Нэмэгдэл	95,170,600.00	120,510,271.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,822,000.00
210104	Урамшуулал	23,725,779.00	32,968,850.59
210105	Гэрээт ажлын хөлс	25,101,800.00	7,146,487.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<u>61,096,779.00</u>	<u>57,630,057.48</u>
210201	Тэтгэврийн даатгал	44,786,911.00	39,756,630.93
210202	Тэтгэмжийн даатгал	4,077,467.00	4,668,320.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,261,934.00	3,701,316.11

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	815,533.00	861,754.35
210205	Эрүүл мэндийн даатгал	8,154,934.00	8,642,036.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,023,544.00	18,480,123.63
210301	Гэрэл, цахилгаан	2,529,594.00	3,616,123.63
210302	Түлш, халаалт	10,293,950.00	13,664,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,093,239.67	59,649,840.00
210401	Бичиг хэрэг	2,235,690.00	5,122,800.00
210402	Тээвэр, шатахуун	21,560,940.00	42,660,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,394,309.67	2,710,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.00	3,036,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,302,300.00	6,119,550.00
2105	Нормативт зардал	107,983,628.00	88,113,533.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,310,728.00	60,518,683.33
210502	Хоол, хүнс	13,678,900.00	17,320,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,994,000.00	10,274,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,229,800.00	20,357,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	735,000.00	165,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	995,000.00	6,192,500.00
210604	Урсгал засвар	8,499,800.00	14,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,474,000.00	1,932,000.00
210702	Дотоод албан томилолт	1,474,000.00	1,932,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,246,700.00	3,117,884.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,665,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	84,000.00	226,080.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,000.00	162,974.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	506,000.00	00.00
210807	Газрын төлбөр	65,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	288,700.00	343,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,112,650.00	11,897,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,112,650.00	11,897,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,800,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,800,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	00.00
213	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0,00	3,749,276.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0,00	3,749,276.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	100,489,097.33	213,144,948.24
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	86,300,000.00	40,171,300.00

Аудитын код: ХӨА-2023/92/НА-СТА-ТШЗ

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	86,300,000.00	40,171,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	86,300,000.00	40,171,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,900,000.00	40,164,170.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,900,000.00	-40,164,170.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,033,215.53	158,784,550.91
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	14,189,097.33
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,033,215.53	172,973,648.24

2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	248,308,287.64	618,336,944.44
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	4,490,974.74	248,308,287.64	618,336,944.44
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	269,328,439.00	4,490,974.74	248,308,287.64	618,336,944.44
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269,328,439.00	4,490,974.74	248,308,287.64	618,336,944.44
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	22,797,563.27	22,797,563.27
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	271,105,850.91	641,134,507.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,189,097.33	(14,189,097.33)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	923,988,000.00	777,415,810.39	146,572,189.61	84.1
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	923,988,000.00	777,415,810.39	146,572,189.61	84.1
210	Бараа, үйлчилгээний зардал	923,888,000.00	777,415,810.39	146,472,189.61	84.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,222,100.00	476,065,821.95	37,156,278.05	92.76
210101	Үндсэн цалин	288,669,100.00	311,618,213.02	(22,949,113.02)	107.95
210102	Нэмэгдэл	158,300,000.00	120,510,271.34	37,789,728.66	76.13
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	3,480,000.00	3,822,000.00	(342,000.00)	109.83
210104	Урамшуулал	33,954,000.00	32,968,850.59	985,149.41	97.10
210105	Гэрээт ажлын хөлс	28,819,000.00	7,146,487.00	21,672,513.00	24.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,092,700.00	57,630,057.48	6,462,642.52	89.92

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	45,663,000.00	39,756,630.93	5,906,369.07	87.07
210202	Тэтгэмжийн даатгал	4,607,400.00	4,668,320.08	(60,920.08)	101.32
210203	ҮОМШӨ ний даатгал	3,685,900.00	3,701,316.11	(15,416.11)	100.42
210204	Ажилгүйдлийн даатгал	921,500.00	861,754.35	59,745.65	93.52
210205	Эрүүл мэндийн даатгал	9,214,900.00	8,642,036.01	572,863.99	93.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,736,600.00	18,480,123.63	256,476.37	98.63
210301	Гэрэл цахилгаан	2,880,000.00	3,616,123.63	(736,123.63)	125.56
210302	Түлш, халаалт	13,664,000.00	13,664,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,192,600.00	1,200,000.00	992,600.00	54.73
2104	Хангамж, бараа материалын зардал	89,979,100.00	59,649,840.00	30,329,260.00	66.29
210401	Бичиг хэрэг	5,989,800.00	5,122,800.00	867,000.00	85.53
210402	Тээвэр (шатахуун)	58,076,200.00	42,660,790.00	15,415,410.00	73.46
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	5,060,000.00	2,710,000.00	2,350,000.00	53.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,000,100.00	3,036,700.00	2,963,400.00	50.61
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	14,853,000.00	6,119,550.00	8,733,450.00	41.20
2105	Нормативт зардал	133,166,200.00	88,113,533.33	45,052,666.67	66.17
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	102,067,300.00	60,518,683.33	41,548,616.67	59.29
210502	Хоол, хүнс	20,809,400.00	17,320,850.00	3,488,550.00	83.24
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	10,289,500.00	10,274,000.00	15,500.00	99.85
2106	Эд хогшил худалдан авах	74,154,200.00	60,528,800.00	17,125,400.00	81.63
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,879,800.00	26,644,800.00	1,235,000.00	95.57
210602	Тавилга	13,691,500.00	13,691,500.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	18,582,900.00	6,192,500.00	12,390,400.00	33.32
210604	Урсгал засвар	14,000,000.00	14,000,000.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,064,100.00	1,932,000.00	1,132,100.00	63.05
210702	Дотоод албан томилолт	3,064,100.00	1,932,000.00	1,132,100.00	63.05
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	12,644,500.00	3,117,884.00	9,526,616.00	24.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,310,900.00	1,665,000.00	6,645,900.00	20.03
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	886,500.00	720,000.00	166,500.00	81.22
210803	Даатгалын үйлчилгээ	390,000.00	226,080.00	163,920.00	57.97
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,200.00	162,974.00	84,226.00	65.93
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	78,200.00	-	78,200.00	-
210806	Мэдээллийн технологийн зардал	717,400.00	-	717,400.00	-
210807	Газрын төлбөр	91,800.00	-	91,800.00	-

Аудитын код: ХӨА-2023/92/НА-СТА-ТШЗ

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,922,500.00	343,830.00	1,578,670.00	17.88
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,828,500.00	11,897,750.00	2,930,750.00	80.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,828,500.00	11,897,750.00	2,930,750.00	80.24
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000.00	-	100,000.00	-
	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	-	100,000.00	-
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	100,000.00	-	100,000.00	-
1320	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	758,459,000.00	862,666,923.63	(104,207,923.63)	101.06
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,403,100.00	34,653,823.63	3,749,276.37	90.23
1340	Орон нутгийн төсвөөс	38,403,100.00	34,653,823.63	3,749,276.37	90.23
134002	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	720,055,900.00	828,013,100.00	(107,957,200.00)	103.49
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	720,055,900.00	828,013,100.00	(107,957,200.00)	103.49
131104	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	89,103,300.00	74,814,200.00	14,289,100.00	83.96
4	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,103,300.00	74,814,200.00	14,289,100.00	83.96
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,189,097.33	(14,189,097.33)	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	172,973,648.24	(172,973,648.24)	-
61	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
62	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
620001	АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	29.00	29.00	100.00
620002	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	100.00
620003	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	21.00	100.00
	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	7.00	100.00
	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн

мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан¹ 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан² тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам-ийн дагуу Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 02 сарын 03-ны өдрийн А/04 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд 13 заалт бүхий 5 ажлын ажлын төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

¹ “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

² “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төв нь нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,766.6 мянган төгрөгөөр буюу 3,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,189.0	172,973.6	158,784.5
Авлага	61,508.2	155.0	-61,353.1
Бараа материал	122,827.0	144,885.9	22,058.9
Үндсэн хөрөнгө	421,546.6	323,119.8	-98,426.8
Нийт хөрөнгө	620367.9	641,134.5	20,766.6

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Өр төлбөр	2,031.0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	269,328.4	269,328.4	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	620367.9	641,134.5	20,766.6

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, авлага, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 158,784.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 22,058.9 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 98,426.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 82,057.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 179,453.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Өмнөх оны Эрүүл мэндийн даатгалаас авах 61,805.2 мянган төгрөгийн авлага хаагдсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 771,514.70 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 38,403.1 мянган мянган төгрөгийн санхүүжилтийг авахаар төлөвлөсөн. Нийт зарлагыг 758,459.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид 2021 оны 07-р сарын 08-ны өдөр хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас 896,778.8 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 34,653.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 931,432.6 төгрөг байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүйтэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 172,973.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			Биелэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	343,616.30	473,187.80	-129,571.50	137.71%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	287,336.30	337,477.50	-50,141.20	117.45%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	89,103.30	86,113.50	2,989.80	96.64%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	25,729.40	21,980.10	3,749.30	85.43%
5	Нийтлэг үйлчилгээ	12,673.70	12,673.70	0.00	100.00%
	Нийт дүн	758,459.00	931,432.60	-172,973.60	122.81%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 61,805.2 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, Аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,052,986.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 21,059.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 14,741.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн

байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт тогтоогоогүй, зөвлөмж өгөөгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан 60,600.0 мянган төгрөг, нягтлан бодогч 1,600.0 мянган төгрөгөөр давхар цалинжсан, шилэн дансанд байршуулахаас 89,900.0 мянган төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нийт 152,100.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	152,100.0	3	152,100.0	100
Нийт дүн	3	152,100.0	3	152,100.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер

зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 25,717.7 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт хийсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 81,375.6 мянган төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 64,769.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 16,605.7 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 61,805.2 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 2,964.7 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 16,605.7 мянган төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, 16,605.7 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 155.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага үүсгэхгүй ажиллах

2. Бараа материал холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү 10,260.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁵ дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁵ "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 6,190.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг санхүүжилт дээр нэмж Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	61,805.2			1	61,805.2	1	61,805.2				
Эдийн засгийн ангилал буруу сонгосон	1	2,964.7			1	2,964.7	1	2,964.7				
Дүн	2	64,769.9			2	64,769.9	2	64,769.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	155.0					1	155.0				
Сарын бодит хэрэглээнээс илүү материал бэлтгэсэн	1	10,260.4					1	10,260.4				
Анхан шатны баримт дутуу	1	6,190.3					1	6,190.3				
Дүн	3	16,605.7					3	16,605.7				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

Х.ДИЙМАА ОГНОО:

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

